

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулиас эрхлэн гаргадаг –ЭДИЙН ЗАСАГ: онол практик I сэтгүүлийн ээлжит дугаарыг Та бүхэндээ толилуулж байна.

Энэ удаагийн дугаарт нийтлэгдэж байгаа өгүүллүүд нь эдийн засаг, мэдээллийн технологи, маркетинг, эдийн засгийн сэтгэлгээний түүх, боловсролын салбар дахь тулгамдсан асуудлуудыг хөндөж уншигч олны анхааралд хүргэж байгаагаараа онцлог юм.

Энэхүү дугаарт –ОХУ, БНХАУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, Зарим бүтээгдэхүүний албан татварын хууль-ийн эдийн засгийн нөлөөллийн судалгаа, –Арилжааны банкуудын мэдээллийн технологийн хөгжлийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа зэрэг цаг үеэ олсон өөрийн гэсэн өвөрмөц өнгө аястай, анхаарч үзүүштэй санал зөвлөмжүүдийг тусгасан олон өгүүллүүд нийтлэгдэж байгаа тул Та бүхний сонирхолыг зүй ёсоор татна гэдэгт итгэлтэй байна.

Түүнчлэн Казахын тээвэр, мэдээллийн академийн дэд эрдэмтэн, доцент Кушукбаев Кайролла Хабасович, дэд эрдэмтэн, доцент Мурзабекова Кенжегуль Абсултанова нарын бичсэн –Тээвэр логистикийн төвийн үйл ажиллагааны нөхцөл ба түүнийг Казахстанд байгуулах арга механизм сэдвээр хийсэн судалгааны ажлын үр дүнг нийтлэж байна.

Академич П.Лувсандорж
Профессор Б.Сувд

Зохиогчид

Н.Батнасан. МУИС-ийн ЭЗС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Судалгааны чиглэл нь **Худалдааны бодлого, салбар хоорондын баланс хүний хөгжил** Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээл –**Монголын хүний хөгжлийн илтгэл 2007** УБ.2007 хамтран зохиогч, редактор –**Хүний хөгжил сурах бичиг** УБ.2008.

Н.Болор. Доктор PhD. МУИС-ийн ЭЗС-ийн менежментийн тэнхимийн багш. Судалгааны чиглэл **Хөгжлийн эдийн засаг, өрсөлдөх чадварын эдийн засаг, уул, уурхайн эдийн засаг.**

С.Бурмаа. Докторант. МУИС-ийн Завхан аймаг дахь ЭЗС-ийн Менежментийн тэнхимийн багш,

Ж.Бурмаа. Идэр дээд сургуулийн багш, Судалгааны чиглэл: **Орон сууцны зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийн өнөөгийн байдал цаашдын хандлага.**

Ц.Бямбадорж. МУИС-ийн Завхан аймаг дахь ЭЗСС-ийн эдийн засгийн онолын багш, магистр. Судалгааны чиглэл: **Шилжилт, бүс нутгийн хөгжлийн асуудал.**

М.Эрдэнэчимэг. Докторант. МУИС-ийн Завхан аймаг дахь ЭЗСС-ийн захирал .

Д.Нар-од. Докторант. МУИС-ийн Завхан аймаг дахь ЭЗСС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн эрхлэгч.

К.К.Хабасович, М.К.Абсултановна. ОХУ-ын Казахстан дахь Тээвэр харилцааны академийн доктор.

П.Оюунбилэг. Доктор(PhD).Математик, компьютерийн тэнхимийн багш,судалгааны чиглэл: **Банк,санхүүгийн мэдээллийн систем.**

Я.Отгонсүрэн. Доктор(PhD) рсдалгаамы рэдэв: –**Байгууллагын маркетинг**Сүүлийн бүтээлээс —**Байгууллагын маркетингийн удирдлага** 2008 —**Үйлчилгээний маркетинг** 2008 2 дахь хэвлэлүүд.

Ч.Баянжаргал. Доктор(PhD) Эдийн засгийн ухааны доктор, профессор. ХҮДС-ийн ЭЗОМТ-ийн багш, Судалгааны чиглэл: **Эдийн засгийн онол болон монголын эдийн засгийн түүх.** Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: –**Монголын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: хувьсал шинэчлэл** хамтарсан бүтээл 2008, —**Чингис хааны гүн ухаан, шинэ мянган**2006, –**Хувийн өмч**(орчин үеийн онолын тойм)2006

З.Бороо. Доктор(PhD).БНСУ-ын Солонгос судлалын төв хүрээлэнд, Судалгааны чиглэл нь:**Олон улсын хөрөнгө оруулалт**. Сүүлийн бүтээл:**Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох** 2008, —**Гадаадым шууд хөрөнгө оруулалтыг шийдвэрлэгч хүчин зүйлс** 2005.

Г.Билгээ. Докторант. Мандах дээд сургуулийн нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш